

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЯВЦЫН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2021 оны 07 сарын 05

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, хүрсэн түвшинг тусгагдсан зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, удаашралтай хэрэгжиж байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад явцын хяналт-шинжилгээний зорилго оршино.

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ, ДҮГНЭЛТ**

Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан ажиллав.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1-т заасан арга зүйгээр явцын хяналт шинжилгээ хийхдээ ТЗУХ-ээс ирүүлсэн тайланд үндэслэн хийсэн.

№	Агуулга	Зорилгын тоо	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Нийт хувь
1	“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	1	1	7	<b>60</b>
2	Хүний хөгжлийн бодлого	5	18	69	<b>35.4</b>
3	Эдийн засгийн бодлого	2	10	47	<b>32.2</b>
4	Засаглалын бодлого	3	8	34	<b>25.1</b>
5	Ногоон хөгжлийн бодлого	1	6	9	<b>61.7</b>
6	Орон нутгийн хөгжлийн бодлого	1	2	11	<b>25.4</b>
<b>Дүн</b>		<b>13</b>	<b>45</b>	<b>177</b>	<b>39.9</b>

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ хийхэд 45 зорилтын 177 арга хэмжээний дундаж эхний хагас жилийн байдлаар 39.9 хувьтай хэрэгжиж байна. Үүнийг салбараар нь харуулбал

№	Бүлэг, салбараар	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн үр дүн				
			100 хувь	50 хувиас дээш	50 хувиас доош	0 хувьтай	ХБ
<b>НЭГ. "КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b>							
1	Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлэх	7	3	-	-	2	2
<b>ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>							
2	Эрүүл мэнд	17	2	2	3	6	4
3	Биеийн тамир, спорт	7	-	-	1	2	4
4	Боловсрол	19	5	1	1	7	5
5	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	13	3	2	-	6	2
6	Үндэсний бахархал, өв соёл	13	4	2	2	3	2
<b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>							
7	Санхүү, төсвийн зохицуулал	4	2	2	-	-	-
8	Уул уурхай, хүнд үйлдвэр	4	-	1	-	1	2
9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр	25	3	1	1	18	2
10	Аялал жуулчлал	6	-	-	-	2	4
11	Эрчим хүч	5	1	-	1	3	-
12	Тээвэр, логистик	3	1	-	-	2	-
<b>ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>							
15	"Цахим Монгол"- төрийн шуурхай үйлчилгээ	5	1	-	2	2	-
16	Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба	10/3 арга хэмжээний тайлан ирээгүй.	3	-	-	1	3
17	Хүний эрхийг дээдэлсэн амар тайван, аюулгүй нийгэм	12	1	-	-	11	-
18	Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого	3	-	-	-	3	-
19	Батлан хамгаалах	4	-	-	1	3	-
<b>ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>							
20	Ногоон хөгжил	9	2	2	2	-	3
<b>ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>							
21	Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил	11	1	1	3	6	-


## ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО



## ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО



## ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО



### АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭЛТЭС АГЕНТЛАГУУД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

2021.7.05

Хэлтэс нэр Нийт арга хэмжээний тоо	Агентлаг	Нийт арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн 100%	Үүнээс			
				50-99 %	1-49 %	0 %	ХБ
ХОХБТХ 65	<b>ХОХБТХ</b>	<b>14</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>6</b>	<b>2</b>
	ГХБХБГ	9	1	1	1	6	-
	ОНӨГ	2	1	1	-	--	-
	БОАЖГ	15	2	2	2	2	<b>7</b>
	ХХААГ	23	3	1	1	16	<b>2</b>
	МЭГ	2	-	-	-	2	-
ТЗУХ - 16	<b>ТЗУХ</b>	<b>8</b>	<b>1</b>	-	<b>1</b>	<b>6</b>	-
	ОБГазар	4	1	-	-	3	-
	ЦШ	4	-	-	1	3	-
СТСХ - 2	<b>СТСХ</b>						
	ТХэлтэс	2	1	1	-	-	-
НБХ - 79	<b>НБХ</b>	<b>18</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>6</b>
	БСУГ	22	7	1	1	7	<b>6</b>
	ЭМГ	21	3	2	3	8	<b>5</b>
	ГБХЗХГ	2	-	-	-	2	-
	ХХУГ	7	2	1	-	4	-
	БТСГ	7	-	-	1	2	<b>4</b>
ХЭЗХ-15	НДХ	2	2	-	-	-	-
	<b>ХЭЗХ</b>	<b>4</b>	<b>2</b>	-	-	<b>1</b>	<b>1</b>
	Архивын тасаг	2	-	-	-	2	-
	ШШГГ	1	-	-	-	1	-
	ШША	1	-	-	-	1	-
	ЦГазар	6	-	-	-	6	-
УБХ	1	-	-	-	1	-	

## **ДҮГНЭЛТ**

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2016-2020 оны төлөвлөгөөний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1- т заасны дагуу зорилт, арга хэмжээг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан хэрэгжилтийн явцад явцын хяналт шинжилгээг хийлээ.

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны төлөвлөгөөний явц 45 зорилтын 177 арга хэмжээг 39.9 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна. Үүнээс 46 арга хэмжээ нь үр дүнтэй буюу тодорхой үр дүнд хүрч хэрэгжсэн байна. Үлдсэн 131 арга хэмжээ буюу 74 хувьд эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй хэрэгжиж байна гэсэн үзүүлэлт гарч байгаа нь цаашид төлөвлөлтөд тусгагдсан арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Мөн шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшиндээ хүрсэн эсэх талаар огт тайлагнахгүй нуршуу, зорилтот түвшиндээ хүрсэн эсэх нь тодорхойгүй, тоо баримт нь зөрүүтэй, өөр тайлан бичсэн зэрэг тайлагналт хангалтгүй байна.

Иймд хэлтэс агентлагийн дарга нар тайлангаа хянаж ирүүлэх шаардлагатай байна.

### **Цаашид авч хэрэгжүүлэх санал зөвлөмж**

1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг судлан ажилдаа мөрдөх
2. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг ойлгомжтой байдлаар, тоо баримттайгаар үр дүнд хүрсэн эсэхийг тодорхой байдлаар баримтжуулан тайлагнах
3. Холбогдох хэлтэс, агентлагууд эхний хагас жилд 50 хувьд хүрээгүй байгаа 17 арга хэмжээ, Тасарч болзошгүй буюу 0 хувьтай байгаа 81 арга хэмжээ, хугацаа

болоогүй байгаа 33 арга хэмжээг сүүлийн хагас жилд эрчимжүүлэх /Хэлтсийн дарга нар чиглэл өгөх/

4. Онлайнар зохион байгуулах боломжтой арга хэмжээг зохион байгуулж хэрэгжилтийг эрчимжүүлэх

ХЯНАСАН :

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Г.САМДАНЦООДОЛ

ЯВЦЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.ДААРИЙМАА